



МОНГОЛ УЛС  
ХОВД АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2021 оны 11 сарын 02 өдөр

Дугаар А/641

Ховд

Алтайн буйлаастын байрны гадна холигч насосны узелийг авч ГЦЦЭ, Алтайн буйлаастын байрнуудын гадна нэгдсэн худганд холигч насосны узель шилжүүлж угсрах ажлыг хүлээн авах ажлын хэсэг байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.2-ын “б”, Барилгын тухай хуулийн 35 дугаар зүйлийн 35.1.6, Засгийн газрын 2021 оны 212 дугаар тогтоолын хавсралтаар батлагдсан барилга байгууламжийг ашиглалтад оруулах дүрмийн 1 дүгээр хавсралтын 2, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 78 дугаар зүйлийн 78.2.4 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар “Цацаг” ХХК-ийн хийж гүйцэтгэсэн Алтайн буйлаастын байрны гадна холигч насосны узелийг авч ГЦЦЭ, Алтайн буйлаастын байрнуудын гадна нэгдсэн худганд холигч насосны узель шилжүүлж угсрах ажлыг хүлээн авах ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэйгээр байгуулсугай.

Ажлын хэсгийн ахлагч: Б.Туулайтулга	- Жаргалант сумын Засаг даргын орлогч
Гишүүд: Н.Цацралцэцэг	- Мэргэжлийн хяналтын газрын эрчим хүчний хяналтын Улсын байцаагч
Р.Янжмаа	- Аймгийн Эрчим хүчний зохицуулах зөвлөлийн орон тооны гишүүн
Б.Түмэндэмбэрэл	- Аймгийн Засаг даргын Тамгын газрын Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого, төлөвлөлтийн хэлтсийн ахлах мэргэжилтэн
Ц.Цолмонбаатар	- Стандарт хэмжил зүйн хэлтсийн салбар сан хариуцсан мэргэжилтэн
Г.Тунгалаг	- Жаргалант сумын Захирагчийн ажлын албаны мэргэжилтэн

- Ц. Бэхбаяр - Магсаржав багийн Нийгмийн ажилтан  
Б.Түмэнжаргал - Орон нутгийн өмчийн газрын мэргэжилтэн  
С.Батдорж - Аймгийн Архивын тасгийн дарга  
Б.Бямбажав - “Цацаг” ХХК-ийн захирал

Нарийн бичгийн  
дарга: С.Өнөржаргал - Газрын харилцаа барилга хот байгуулалтын  
газрын дэд бүтэц хариуцсан мэргэжилтэн

2. “Цацаг” ХХК-ийн хийж гүйцэтгэсэн ажлыг захиалагчаас өгөгдсөн ажлын тоо хэмжээтэй тулган шалгаж, өмч бүртгэлд тусгаж хүлээн авах эсэх талаар шийдвэр гарган танилцуулахыг ажлын хэсгийн ахлагч /Б.Туулайтулга/-д даалгасугай.

ЗАСАГ ДАРГЫН  
ОРЛОГЧ



Т.ЖАРГАЛСАЙХАН